

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Хөвсгөл аймагт төрийн албаны ерөнхий шалгалт 11 дүгээр сард амжилттай зохион байгуулж дууслаа.

Энэ удаагийн шалгалтад 359 иргэн бүртгэгдэж, 294 иргэн шалгалтад орж, 102 иргэн шалгалтад тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэх боломжтой боллоо.

Багийн Засаг дарга нарын манлайлал, ёс зүйг дээшлүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын уялдаа холбоог хангах, “Багийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө-3”-ыг танилцуулах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын “Соёмбо танхим”-д аймгийн ИТХ, АЗДТГ, Статистикийн хэлтэс, Тогтвортой амьжиргаа 3 төсөлтэй хамтран Төрийн захиргааны удирдлагын хэлтэс ерөнхий зохион байгуулалтыг ханган “Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах” сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Сургалтад аймгийн хэмжээний 129 багийн Засаг дарга, Мөрөн сумын 14 багийн баг зохион байгуулагч нарт оролцов. Эдгээр 129 багаас анх удаа сонгогдсон 68 багийн Засаг дарга байв.

**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2021 оны 11-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 10.5 тэрбум төгрөгний **2283** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 10-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 23,732.2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 27,443.4 сая төгрөг буюу 115.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2021 оны 10-р сарын мэдээгээр Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 129,821.1 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 45,152.3 сая төгрөг нь улсын төсвөөс санхүүжих, 58,293.5 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 15,641.6 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 4,082.0 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 6,651.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 129,821.1 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 118,916.1 сая төгрөг буюу 91.6 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт энэ сард дутуу ирсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **4,625.5** сая төгрөг өмнөх сараас **164.7** мянган төгрөгөөр буурсан.

Нийт өглөг **1,190.6** сая төгрөг өмнөх сараас **15.2** сая төгрөгөөр буурсан байна.

2021 оны 11 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 2535.8 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 275.5 сая төгрөгийн, шимтгэлийн орлого нийт 2811.3 сая төгрөг буюу 103 хувиар биелүүлсэн.

Төлөвлөгөөг сан тус бүрээр харуулбал:

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2400.9	2468.6	102.8
Тэтгэмж	200.4	210.1	104.8
ҮОМШӨ	87.8	90.1	102.6
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	40.3	42.5	105.5
дүн	2729.4	2811.3	103

Тэтгэврийн даатгалын сангаас 20680 тэтгэвэр авагчид 7628.5 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 294 даатгуулагчдад 340 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 97 даатгуулагчдад 63.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1161.7 сая төгрөг байна.

Манай байгууллага аймгийн Засаг даргын тамгын газраас “Иргэдээ сонсох” нэрлэсэн жилийн ажлын хүрээнд 2021 оны “Засаглал, эрсдэлийн удирдлагыг эрчимжүүлэ” нэрлэсэн жил болгон зарлаж, байгууллагын хэмжээнд авч хэрэгжүүлэх болон цаг үеийн байдалтай холбоотой нийт 8 дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэн тухай бүр холбогдох байгууллагад нь тайлагнан ажиллаж байна

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод аудитын нэгж, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан дотоод аудитын нэгжийн тайлан мэдээг сар бүр авч дүгнэн ажиллаж байна.

2021 оны 11 дүгээр сарын байдлаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дагуу нийт 75 байгууллагад хийж 2021 оны төлөвлөгөөний биелэлт 40 хувьтай байгаа бөгөөд одоо Цагааннуур, Улаан-Уул сумдад санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Байгууллагын хэмжээнд 2021 оны 11-р сарын 20-ны байдлаар 292 албан бичиг хүлээн авч, хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 283 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаа.

## **Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :**

Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр :

Хөвсгөл аймгийн хэмжээнд хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг 72 объектод төлөвлөснөөс 59 объектод хяналт шалгалт хийгдэж, төлөвлөгөөний биелэлт 82.0 хувьтай байна. Хяналт шалгалтад хамрагдсан объектуудад холбогдох хяналтын хуудсаар үнэлгээ хийж эрсдэлийг тооцоход 1 объект бага, 27 объект дунд, 31 объект их эрсдэлтэй үнэлэгдэж, эрсдэлийг бууруулах, зөрчлийг арилгуулах чиглэлээр 59 албан шаардлагыг аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласны дүнд зөрчлийн 79.0 хувийг арилгуулж, 45 объектын эрсдэл буурсан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан борлуулалтын үйл ажиллагаа шинээр эрхлэгч нийт 29 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, биелэлт 96.5 хувьтай байна. Хяналт шалгалтад хамрагдсан объектуудад холбогдох хяналтын хуудсаар үнэлгээ хийж эрсдэлийг тооцоход 2 объект бага, 10 объект дунд, 16 объект их эрсдэлтэй үнэлэгдэж, эрсдэлийг бууруулах, зөрчлийг арилгуулах чиглэлээр нийт 28 зөвлөмж гарган хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласны дүнд зөрчлийн 84.7 хувийг арилгуулж, 23 объектын эрсдэл буурсан байна.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/05 дугаартай удирдамжийн дагуу давхардсан тоогоор нийт 35 хүнсний үйлдвэр, цех, 32 хоолны газар, 296 худалдааны газрын түүхий эд, бүтээгдэхүүний чанар стандарт, хадгалалт, хамгаалалт, гарал үүсэл, баталгаажилт, хоол, хүнс үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт 821 зөрчлийг илрүүлж, 642 буюу 78.3 хувийг нь арилгуулж, 6 цех, 7 худалдааны газарт хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг хангуулан зөрчлийг арилгуулж ажиллалаа. Шалгалтын явцад бууз, банш, хиам, зайдас, хэвийн боов, шанзтай еэвэн зэрэг нийт 21 нэрийн бүтээгдэхүүнээс 76 дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулан, хадгалалтын хугацаа дууссан, чанар аюулгүй байдлын шаардлага хангахгүй 56 нэрийн 120.1 кг, 1021 ширхэг, 4.089.200 төгрөгийн бүтээгдэхүүнийг хураан авч, устгуулахаар аймгийн Засаг даргын зөвлөлд шилжүүлж, илэрсэн зөрчилтэй холбогдуулж 1 аж ахуй нэгж, 2 иргэнд нийт 1.100.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч барагдуулан, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа.

Эм био бэлдмэлийн хяналтын чиглэлээр:

Их дунд эрсдэлтэй 4 объектыг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулахаар төлөвлөснөөс жилийн эцсээр 4 объектыг хамруулснаар төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна. Эм хангамжийн байгууллага нийтийн үйлчилгээтэй 3 эмийн сангуудыг 3.3 кодтой хяналтын хуудсаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд хууль сахин мөрдөлтийн хувь 61.3%, эрсдэл үүсэх магадлалын хувь 41%, 59 зөрчил илэрч 3



1	2	3	4	5	6	7	8	9	10	11
254	1242	83	1	100000		10	-	-	-	2

Цаг агаарын аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг утсан холбоо ашиглан албад, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, 23 сум, 1 тосгонд хүргэн ажиллаж байна. Мөн багц мессэж үйлчилгээг ашиглан орон нутгийн 4800 гаруй малчин өрхийн утсанд сэрэмжлүүлэг мэдээг дамжуулсан.

Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын хэмжээнд ашиглагдаж байгаа холбооны техник хэрэгслийн судалгааг хойд бүсийн төв Орхон аймгийн Онцгой байдлын газрын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан операторт хүргүүлсэн.

2021 оны 11 сард ирсэн гал түймэр болон гамшиг ослын мэдээллийг оруулсан. Үүнд: гал түймрийн 5, газар хөдлөлтийн 2 зураглалыг оруулсан. Мөн эрэн хайх, аврах ажиллагааны 3 дуудлагын зураглалыг тухай бүрд оруулсан.

Орон зайн мэдээллийн системийн Шуурхай штабын Ковид 19 нөхцөл байдал арга хэмжээний талаар хуудсан дээр аймгийн мэдээллийг сум, аймгаар нь тогтмол шинэчилж байна. Мөн [covid19.nema.gov.mn](https://covid19.nema.gov.mn) Ковид хяналтын самбарт аймаг болон сум тус бүрээр мэдээллийг шинэчилж, УОК-ын Шуурхай штабын [shtab.gov.mn](https://shtab.gov.mn) сайтад 10 асуумжийн дагуу мэдээллийг өдөр бүр аймгийн Шуурхай штабаас авч системд тогтмол оруулан, хянуулж байсан.

2021.11.19-ний өдөр УОК-ын нэгдсэн шуурхай штабаас зохион байгуулсан шинэ системийн сургалтад аймгийн Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид хамрагдсан. Сургалтын дагуу [arcs.gov.mn](https://arcs.gov.mn) системд аймгийн хэмжээнд вакцин хийгдэж байгаа нийт 28 цэгийн мэдээллийг оруулсан.

Аймгийн Засаг даргын баталсан хуваарь, төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12-ны өдрүүдэд Түнэл суманд гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион явуулав. Сумын Онцгой комиссын гишүүдэд Команд штабын сургалтын удирдаж, хөтөлбөрийг танилцуулан, “Мэргэжлийн ангийн дүрэм, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хэрэгжилт, зохион байгуулалтын талаар, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллах журам болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/274 дүгээр тушаалын хавсралыг танилцуулж сургалт орсон.

Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хянуулан аймгийн Засаг даргаар болон ОБЕГ-ын ГШУГ-ын ахлах мэргэжилтэн дэд хурандаа Б.Мягмарсүрэнгээр хянуулж батлуулав.

ОБЕГ-ын ГШУГ-т Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн хангасан тухай нэгдсэн дүн мэдээ, тайланг хүргүүлэв.

Эрэн хайх аврах ажиллагааны дуудлагаар Хөвсгөл аймгийн Арбулаг, Цагааннуур сумын нутаг Шишхэд голд машинтай 3 иргэн мөс цөмөрч осолдсон дуудлагаар офицер-4, аврагч-11, нийт 5 хоног ажиллаж мөс цөмөрч осолдсон 3 буцалтгүй нэрвэгдэгчийн цогцсыг гаргаж хууль хяналтын байгууллагад шилжүүлж өгч, живсэн автомашинуудыг татаж гаргаж иргэдийн 35000000 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж ажилласан.

Эрэн хайх, аврах салбарын алба хаагчид Онцгой байдлын газрын 2021 оны зорилт, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны дэвшилтэд технологи, стандарт, иновацийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Өвлийн нөхцөлд гол нуурын усанд цөмөрсөн автомашиныг татан гаргахад зориулсан угсардаг дамнуурга, гар ажиллагаатай лёботик санаачлан хийж бэлэн болгосон.

### **Гэмт хэрэг, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:**

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар нь 2021 оны 11 дүгээр сард гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 3806 гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган үзсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тодорхой төрлийн гэмт хэрэг тухайлбал, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, Сэтгэл санаа хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах, Заналхийлэх, Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох зэрэг гэмт хэргийн тоо өссөн үзүүлэлттэй гарчээ.

Дээрх тоон мэдээлэлд үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь гэмт хэрэг зөрчлийн гаралт ихэссэн сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өсөлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах талаарх зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах талаарх чиглэл хүргүүлсэн албан бичгийг хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа.

Мөн Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авилгын эсрэг үйл ажиллагааны 2021 оны аймгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 11 сарын байдлаар нэгтгэж Авилгатай тэмцэх газарт хүргүүлэв

Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдалтай холбогдуулан Авилгатай тэмцэх газрын албан хаагчид зөвлөн туслах, хяналт шалгалтын ажлыг цахимаар 30 хоногийн хугацаанд зохион байгуулав, Уг шалгалтад холбогдох төрийн байгууллагыг хамруулан удирдлага зохион байгуулалтаар хангаж, баримт мэдээллийг цахимаар хугацаанд нь хүргүүлэн ажиллаа.

Авилгатай тэмцэх газраас Авилгын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан олон нийтийн санаа бодлыг сонсох, санал, санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх, авилгатай тэмцэх бодлого, үйл ажиллагааны ололт, амжилт, хүндрэл, бэрхшээлийг дүгнэн хэлэлцэх зорилгоор **“Авилгын эсрэг үндэсний чуулган-2021”-ыг 12 дугаар сарын 08-ны өдөр** зохион байгуулсан. Уг чуулганд аймгийн Засаг дарга, хэлтэс албадын дарга, агентлаг байгууллагын удирдлагуудын хамруулан оролцсон.

“Олон улсын авилгын эсрэг өдөр”-ийг тохиолдуулан “Төрийн үйлчилгээг сайжруулахад-миний санал”сэдэвт уралдааныг зохион байгуулж ажилласан.

## **Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:**

2021 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр 64 хөмрөгийн 64 дансны 389 хадгаламжийн нэгжийн 37676 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүнээс 61 хөмрөгийн 61 дансны 349 хадгаламжийн нэгжийн 31179 хуудас баримтын тодорхойлон бичилтийг хийсэн бөгөөд 2021 оны цахимжуулалтын төлөвлөгөөний биелэлт 74,5 хувьтай байна.

11 дүгээр сард захирамжлалын баримт бичгийн лавлагааг 383 иргэн, 21 байгууллагад 308 хадгаламжийн нэгжээс, мал тооллогын баримтын лавлагааг 178 иргэнд 4711 жилийн А данс, шаардлагатай магадлагаа, тодорхойлолтыг 78 иргэн, 19 байгууллагад гаргаж архивын баримтын үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгаас 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны нэгдсэн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 24 сумын ЗДТГ-ын болон Ерөнхий боловсролын сургуулийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан, төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтнууд нийт 150 гаруй албан хаагч хамрагдсан байна. Сургалтын танилцуулга, мэдээлэл нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

### **БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Орон нутагтаа Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 20 дугаар тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллалаа.

Сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, багш, ажилтан, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад сургалт, сурталчилгааг тогтмол явуулан гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалыг хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн цахим контентын сан бүрдүүлэх зорилгоор “Контент боловсруулах лаборатори байгуулах” байгууллагын зардлын хуваарилалт болон тайлан явуулах талаарх тушаалыг хүргэн хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд боловсролын сэтгэл зүйчийн үзүүлж байгаа сэтгэл зүйн үйлчилгээ болон сурагчдад тулгамдаж байгаа сэтгэл зүйн асуудал бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэсэн байдлыг тодруулах зорилгоор судалгаа авлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 30 –ний өдрийн 275 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын дагуу улсын хэмжээний бүх сум, хорооноос 2021 оны ЭЕШ-

д хамрагдаж журманд заагдсан шалгууруудыг хангасан суралцагчдын мэдээллийг хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарт Боловсролын тухай хуулийн өөрчлөлт, эрх зүйн шинэчлэл, Цахим төсөв-2022, Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, анхаарах асуудал сэдвээр мэдээлэл өгч харилцан санал солилцлоо.

Боловсролын газар, Титэм ЕБС-ийн гадаад хэлний ЗАН-ийн багш нартай хамтран “Гадаад хэлний сургалтын заах аргазүйг сайжруулах, цахим болон танхимын сургалтад шинэ технологийг /Nearpod платформ/ нэвтрүүлж хэрэглээнд оруулах нь” сэдэвт сургалтыг Их уул суманд Сэлэнгэ бүсийн багш нарыг хамруулан зохион байгууллаа.

2021 онд Хөвсгөл аймагт хийгдсэн хөрөнгө оруулалтын явцын мэдээллийг нэгтгэн шинээр хийгдсэн ажлуудыг тусган өмнө явуулсан мэдээллийг шинэчлэн БШУЯ-ны Хөрөнгө оруулалтын газар хүргүүллээ.

“ТХБ-2030 Монгол Улсын санаачилга” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулав.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Нэг цэгийн үйлчилгээний төвөөр нийт 85 хүн үйлчлүүлснээс хүүхэд 16 (эрэгтэй 9, эмэгтэй 7), насанд хүрэгч 69 (эрэгтэй 21, эмэгтэй 48) байна

Аймгийн Цагдаагийн газар, газрын мэргэжилтнүүдтэй хамтран “Тайван амьдрал танай гэрээс-2” сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан аймгийн ХХҮГ, БСУГ, ГБХЗХГ, Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн эмч, мэдрэлийн эмч, ХБХЭЭХ-ны төлөөлөл бүхий 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй баг салбар комиссын хуралдаан зохион байгуулж, 22 хүүхдийн асуудлыг хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хүний биед хүрэх дүрэм, аюултай болон аюулгүй харилцаа, хүсээгүй хүртэхүйн тухай ойлголтыг хүүхдүүдэд өгч, аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх дадал, чадвар олгох зорилгоор “Хүрэхүй” хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2021 оны III улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Авилга, эрүү шүүлт тулгах, хүрээлэн байгаа орчны эсрэг, мансууруулах бодистой холбоотой болон хүүхэд хохирсон гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” чиглэлээр зохион байгуулсан хэлэлцүүлэгт хүүхэд хохирсон гэмт хэрэг, түүний хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, оролцлоо.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Хүүхдийн тусламжийн 108 утасны хариу үйлчилгээний программын шинэчлэлийн цахим сургалтад хуваарийн дагуу оролцлоо.



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, МУБИС-ийн Нийгмийн ажилтны тэнхим хамтран хүүхдийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

Аймаг орон нутгийнхаа хөгжилд, шинэ санаа, санаачилгыг нэвтрүүлж, хөгжил дэвшлийн түүчээ болсон шилдэг, манлайлагч залуусын үйл хэргийг олон нийтэд сурталчлан таниулж, алдаршуулах зорилгоор “Залуу манлайлагч” цуврал контентийг бэлтгэж хүргэсэн.

Монголын залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд “Залуучууд 100 жил-Өнөө ба ирээдүй” эрдэм шинжилгээний бага хурлыг 2 үе шаттайгаар зохион байгуулагдлаа.

“Мэдлэгээ хуваалцъя” сэдвийн хүрээнд Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ? сэдвээр Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн сургалтыг зохион байгуулав.

Өмнөговь аймагт зохион байгуулагдсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” сумын удирдлагуудыг чадавхжуулах сургалтад НҮБ-ын Хүүхдийн сангийн урилгаар газрын дарга болон албан хаагчид хамрагдаж Өмнөговь, Өвөрхангай, Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаатай танилцлаа.

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем /WAIS/-ээр нийт 33437 иргэнд 7.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг олгосон байна.

Нийгмийн халамжийн нэгдсэн систем /EHALAMJ.mn/-ээр 34459 иргэнд 1.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг иргэний арилжааны банканд дахь дансны холболт хийснээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас шууд олголтыг хийн ажилласан. EHALAMJ.MN-ээр доорх үйлчилгээг иргэний хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэсэн.Үүнд:

Харж хандах үр хүүхэдгүй ганц бие ахмад настнуудад түлшний үнийн хөнгөлөлт олгох материалыг 10 сараас хүлээн авсан бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт, шалгалтын ажлын хэсгийн өгсөн албан шаардлагын дагуу мэдээлэл тулгалтын ажлын хийж дуусган 12 сарын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олголт дээр олгохоор ажиллаж байна.

Галт сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Хөдөлмөрч Галтчууд” аян зохион байгуулан 2021 оны 11 дүгээр сараас хүнсний эрхийн бичиггүй аймгийн анхны сумыг бий болгосон. Уг ажлын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байсан өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байранд зуучлах, өвөлжөө хаваржааны газрыг эзэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх сургалтыг суманд ажлын хэсэг зохион байгуулан ажилласан.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД:**

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран Хөвсгөл аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн тоон болон чанарын судалгааг хийж, мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд нийт 263 ажил олгогч, 2115 сурагч, 1049 оюутан, 140 МСҮ-д суралцагч, төгсөгч, 1451 ажилгүй иргэн, 1451 ажилтай иргэн, 1023 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1124 малчнаас судалгааны мэдээллийг цуглуулсан. Төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн зах зээлийн судалгааны мэдээлэл нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

12-р сарын эхний 20-ны дотор судалгааны тайланг олон нийтэд хүргэх ажлыг нэгдсэн арга хэмжээгээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Судалгааны тайланг Улаанбаатар хотод ном болгох ажлыг эхлүүлсэн.

2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар ажилд зуучлагдсан иргэн 534, идэвхтэй ажил хайгч 728 иргэн байна. Шинээр бий болсон ажлын байр 496 үүнээс байнгын ажлын байр 215, улирлын чанартай ажлын байр 80, түр ажлын байр 201 бий болсон байна.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд ажилд зуучлах уулзалтад бэлтгэх арга хэмжээнд 21 иргэнийг хамруулж 1,0 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах удирдамж”-ийн дагуу Мөрөн сумын “Өргөө” ХҮТ-ийн 3 давхрын зааланд нийт 58 албан хаагчийг бүрэн хамруулсан сургалтын үйл ажиллагааг 2021 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 278 дугаар тогтоолын дагуу хууль зөрчин томилсон зарим албан хаагчдыг ажлаас чөлөөлж зөрчлийг арилган ажиллаж байна.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 57 дугаар тогтоолоор 5 иргэнийг томилуулах тогтоол хүлээн авч Бүрэнтогтох, Түнэл, Цагаан-Үүр сумдад нэр дэвшүүлсэн иргэдийг томилсон. Алаг-Эрдэнэ сумын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн мэргэжилтний ажлын байранд тусгай шалгалт өгч тэнцсэн иргэн ажилд орохоос татгалзсан тул дахин сонгон шалгаруулалт хийлгэхээр сул ажлын байрны захиалга хүргүүлсэн.

## **СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Биеийн тамир, спортын салбарын “Төсөв санхүүгийн шинэтгэл” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний аудитын газар, аймаг нийслэл, дүүргийн биеийн тамир спортын газар, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн төлөөллүүд оролцсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 4 дэх удаагийн Дэлхийн аварга шалгаруулах шатрын тэмцээн онлайнаар зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 46 орны 255 тамирчин оюун ухаан, хүч чадал, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн байна.

Монгол улсаа төлөөлөн паралимпийн шатрын холбооны 15-н тамирчин багийн болон ганцаарчилсан төрлөөр оролцож Хөвсгөл аймгаас 6 тамирчин оролцлоо.

Монгол Улсын Засгийн газрын 05 дугаар тогтоолын хүрээнд нийтийн биеийн тамирын арга хэмжээний хүрээнд Монголын ахмадын 30 дах өдөрт зориулсан “Ахмад настны заавал хийх дасгал”-ын цахим арга хэмжээг зохион байгуулж тус арга хэмжээнд 16 байгууллагын 160 гаруй ахмад тамирчид оролцлоо.

Монгол Улсын Засгийн газрын 05 дугаар тогтоолын хүрээнд “Иргэдийн Наадам”-ыг зохион байгуулж Аймгийн хэмжээнд олс таталтын 10 багийн 80 тамирчин, Сагсан бөмбөгийн 40 багийн 280 тамирчин, Волейболын 36 багийн 288 тамирчин авхаалж самбаагаа сорин оролцож нийт 650 хүн хамрагдаж амжилттай болж өндөрлөлөө.

“Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээ нь гимнастикийн олон төрлийн идэвхтэй дасгал хөдөлгөөнийг багтааснаараа онцлогтой болж өндөрлөлөө. Хөвсгөл аймгаас “Цахим гимнастрада” Улсын уралдаанд 26 багийн 240 тамирчин 12 багш дасгалжуулагчид оролцож тэмцээнд ДМЦ сургууль, Ирээдүй ЕБС, Мөрөн сумын 1-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, 14-р цэцэрлэг, 15-р цэцэрлэг, 12-р цэцэрлэг, Үзэсгэлэнтэй зүрх иогийн төв, Мөрөн сумын ахмадууд оролцлоо.

Бие чийрэгжүүлэх “Найман дасгал” хийн дасгалаар 26 баг тамирчид оролцлоо. Хөвсгөл аймаг 1-р байр, ЕБС-ын Дунд ангийн сурагчдын Аэробик гимнастикийн дасгалаар 173 баг тамирчид оролцсоноос 1-р байр, Гэр бүлд зориулсан дасгалаар 57 баг оролцсоноос 3-р байр эзэлсэн амжилттай оролцлоо. Мөн багийн нийлбэр дүнгээр 4-р байр эзэллээ.

Үндэсний бөхийн 2021 оны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 14 байгууллагын 50 гаруй тамирчин 16,17,18 насны ангилалд авхаалж самбаа ур чадвараа сорин барилдлаа.

Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн СЭЛЭНГЭ амралтын баазад зохион байгуулагддаг “Эрдэнэт Опен” багийн аварга шалгаруулах Бадминтоны 11 дэх удаагийн тэмцээнд Хөвсгөл аймгаас анх удаагаа 2 насны ангилалд оролцлоо. Тэмцээнд нийт 23 багийн 100 гаруй тамирчид оролцлоо.

Цар тахлын улмаас цуцлагдаад байсан 2020 оны өсвөр үеийн жүдо бөхийн УАШТ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, Хөвсгөл аймгаас 17 тамирчин оролцож 4 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль тус тус хүртэж, багийн дүнгээр 3-р байр эзэллээ.

Atlanta 96 зуны олимпийн хүрэл медальт МУГТ Д.Нармандахын нэрэмжит жүдо бөхийн өсвөр үеийн тэмцээн Улаанбаатар хотын алдар спортын хороонд зохион байгуулагдаж Хөвсгөл аймгаас 12 баг тамирчид оролцсоноос 1 алт,1 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЕБС-ийн спорт зааланд Токио олимпын танхимын нээлтийн үйл ажиллагаанд “Седней Олимпын” зөвлөл болон БТСГ-ын

сургалт дасгалжуулалтын алба, нийтийн биеийн тамирын чийрэгжилтийн албаны хамт олон оролцож гарын авлага зөвлөмж, спортын хэрэглэл материал гардууллаа.

Хөвсгөл аймгийн 2021 оны насанд хүрэгчдийн аварга шалгаруулах “Шагайн харваан” тэмцээн Мөрөн хотод амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 9 сумын 24 багийн 190 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Уг тэмцээнд Монгол улсын үлэмж дархан мэргэн 1, Монгол улсын мэргэн 4, Аймгийн гоц мэргэн 46, Аймгийн хошой мэргэн 36 болон залуу харваач нар оролцлоо.

Чөлөөт бөхийн өсвөр үе, залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж Хөвсгөл аймгаас 5 тамирчин оролцож өсвөрийн ангилалд 34 байгууллагын 630 гаруй, залуучуудын ангилалд 36 байгууллагын 638 тамирчин оролцлоо.

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн Эрүүл мэндийн салбарын санхүүгийн мэргэжилтэн, нягтлан бодогч нарыг чадвахжуулах, туршлага солилцох сургалтыг зохион байгуулсан. Сургалтад эрүүл мэндийн салбарын бодлого төлөвлөлт, хүний нөөцийн уялдаа холбоо, хууль эрх зүй, төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн санхүүжилт, 2020-2021 оны хөрөнгө оруулалтын бодлого, 2020 оны санхүүгийн жилийн ололт амжилт цаашид анхаарах асуудал, 2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бэлтгэл ажил зэрэг тулгамдсан асуудлуудыг хэлэлцэв.

Мөн "Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах "ТА 9701 төслийн хүрээнд "Стратегийн худалдан авалтын тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн менежментийн чадавхийг бэхжүүлэх" сургалтыг зохион байгууллаа.

"Хүүхэд, өсвөр насныхны өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээ" сэдэвт сургалтыг Мөрөн сумын сургууль цэцэрлэгийн нийт 35 эмчийг хамруулан зохион байгуулж байна. Сургалтыг Хөвсгөл аймгийн сургууль цэцэрлэгийн эмч нарын холбоо, Дэлхийн Зөн Монгол ОНХХ, Бболовсролын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулж мэдээлэл солилцон ажиллаа.

Дэлхийн чанарын өдрийг тохиолдуулан Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар Олон Улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх сургалтын үйл ажиллагаа эхлүүлж байна. Сургалтад ЭМГ-ын ажлын хэсгийн 13 гишүүн оролцож байгаа ба сургалтын дараа нийт албан хаагчдад ISO чанарын стандартыг нэвтрүүлэхэд анхаарах зүйл болон чадвахжуулах ажлыг гүйцэтгэх юм.

Ковид19 халдварыг бууруулах аяны хүрээнд:

Цагаан-Уул сумын Ковид 19 халдварын вакцины 3 дахь тунгийн хамралт 27%, төрийн албан хаагчдын хувьд эрүүл мэндийн төв- 100%, ЕБСургууль-65.7%, СӨББ1-85%, СӨББ2- 86.5%, ЗДТГ- 76.1%, Соёлын төв- 75%, Гал түймэр унтраах 73-р анги-88.8%, Агар застав- 88.2%- тай тус тус хамрагдсан байна.

Бүрэнтогтох сумын Ковид 19 халдварын вакцины 3 дахь тунгийн хамралт 39%, төрийн албан хаагчдын хувьд эрүүл мэндийн төв- 100%, ЕБСургууль-73%, СӨББ-84%, ЗДТГ- 61%, Соёл урлаг, спорт цогцолбор- 50%, Бүрэнхаан бага сургууль - 82%-тай тус тус хамрагдсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Хөвсгөл аймагт ажиллах үедээ аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай амьсгалын аппаратаар хангахаар шийдвэр гаргалаа. Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан албан ёсоор Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн дэмжлэгээр шийдвэрлэсэн 5 ширхэг амьсгалын аппаратыг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Рашаант сумын Эрүүл мэндийн төвүүдэд гардуулан өглөө.

Мөн УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар Хөвсгөл аймагт ажиллах хугацаандаа Унгар Улсын Засгийн газраас хандивласан амьсгалын аппарат 4 ширхэг, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппаратыг Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өглөө.

Монголын Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо ЭМЯ, Глобал сантай хамтран “Сумын эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт анхан шатны эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

### **СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2021 оны 11 дүгээр сарыг Соёлын яамнаас “Соёлын бүтээлч сар” болгон зарлалаа. Соёлын бүтээлч сарын хүрээнд соёл урлагийн салбарын ажилтнуудад зориулсан мэргэжил дээшлүүлэх болон чадавхжуулах сургалтыг зохион байгуулж байна. Мэргэжил дээшлүүлэх сургалтыг соёлын төвийн ажиллагсдад зориулан 5 өдрийн турш зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Хөвсгөл аймгаас 23 соёлын төвийн 79 албан хаагч амжилттай суралцаж сертификатаа авлаа. Мөн “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-Залуучуудын оролцоо” чуулга уулзалтад Хөвсгөл аймгаас 58 залуус цахимаар оролцлоо.

Соёлын хэлтсээс Цагаан-Уул, Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл сумын соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

ЮНЕСКО-ийн Байгаль, соёлын өвийг хамгаалах сан, Соёлын өвийн үндэсний төв, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл, Урлагийн Газартай хамтран зохион байгуулсан "Эх нутаг өв соёлоо эрхэмлэн дээдэлье" 2 жилийн хугацаатай тэргүүн туршлагын улсын уралдаанд 21 аймаг, 360 сум оролцсоноос Чандмань-Өндөр сумын "Хөхөө толгой" тахилгат газар 3-р байр эзэллээ.

Монголын Үндэсний номын сангаас зохион байгуулсан "Би шилдэг номын санч" улсын уралдаанд соёлын төвийн номын сангийн төрөлд Бүрэнтогтох сумын соёлын

төвийн номын санч Э.Ариунтунгалаг, ЕБС-ийн төрөлд “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн номын санч Б.Дэлгэрмөрөн, Х.Энхтуяа нар тэргүүн байр эзэллээ.

Хөгжимт драмын театр өвөл цагийн нээлтээ хийж хөгжим ангийн бие даасан “Хоймор эгшиглэн” тоглолтыг толилуулсан бөгөөд дэлхийн болон Монголын хөгжмийн зохиолчдын шилдэг бүтээлүүдээс бүрдсэн, үндэсний язгуур урлаг, этник, сонгодог бүтээлүүдийг хослуулсан орчин үеийн шинэлэг тавилттай тоглолт боллоо. Мөн тус театрын үйлчлэгч Б.Оюунаагийн эмчилгээний зардалд хандив болгон “Амьдрал бэлэглээ” тоглолтыг зохион байгууллаа.

Монгол Улсад орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын хүрээнд аймгийн "Номын санчдын анхдугаар чуулган"-ыг амжилттай зохион байгуулагдлаа. Анхдугаар чуулганы үеэр ЕБС-ийн болон сумдын соёлын төвийн номын санчдад Ном зүй, түүний төрөл хэлбэр, ном зүйн бүртгэлийг хэрхэн ашиглах, шинэ номын мэдээ бэлтгэх, Сан хөмрөгөөс ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг хасах зэрэг сэдвээр хичээл бэлтгэж сургалт явууллаа. Мөн “Номын санч” сэтгүүлийн бүх дугаараар үзэсгэлэн гаргаж, номзүй бичлээ. Нийтийн уншлагын танхимаас “Шинэ номын үзэсгэлэн”, Гэрээр ном олгох танхимаас “Номын сантай холбоотой ном, сэтгүүл, номын санчдын мэргэжлийн ном хэвлэл”-ээр үзэсгэлэн гаргаж, номзүй бичлээ.

Хүүхдийн уншлагын танхим 6 ястны онцлогийг харуулсан булантай болж, мэдээллийн самбар, бяцхан урц зэрэг үзмэрийг бий болгов. “Номын мухлаг 599 төгрөг” байнга ажиллаж байна. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд “Ардын билиг зүйч Ж.Бадраагийн дууг хэн сайн дуулах вэ?” уралдааныг зохион байгуулахаар удирдамжийг олны хүртээл болголоо.

Аймгийн музейн үзэл баримтлал боловсруулах ажлын хэсэг анхны хурлаа хийж санал солилцлоо. “Ягаан хана” буландаа 2 зочин урьж оролцуулан цахим хуудаснаа байрлуулж 4 удаа үзэсгэлэн дэглэн 3082 хүнд хүргэлээ.

ХДТ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтцийн орчныг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Эерэг хандлага – Ээлтэй дэд бүтэц” аяны хүрээнд “Түмний телевиз”-тэй хамтран ажиллаж “Эерэг хандлага – Ээлтэй дэд бүтэц” нэрийн дор жүжиглэсэн хэлбэрээр 3 минутын видеог бэлтгэж байгууллагын пэйж хуудас, Түмний телевизийн пэйжээр дамжуулан үзэгчдэд ээ хүргэж байна.

ХДТ-ын уран бүтээлчдийн дунд мэргэшсэн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Би мэргэжлийн уран бүтээлч” гурван сарын аян зохион байгуулж байна. Мөн Хатгал тосгоны соёлын төвтэй хамтран ажиллаж мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч хамтарсан тоглолт зохион байгуулж ажиллалаа.

### **Зургаа мал аж ахуй, өвөлжилтийн талаар:**

Аймгийн ургац хураалтын нэгдсэн дүн мэдээг гаргаж ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Энэ онд аймгийн дүнгээр үр тариа 15875 га-д үүнээс улаан буудай 15500 га-д, арвай

240 га-д, овъёос 85 га, хөх тариа 50 га, мөн малын тэжээл 950, тосны ургамал 400 га, төмс 289 га, хүнсний ногоо 186 га, жимс- 105 га –д тус тус тариалах төлөвлөгөө өгөгдөж 19094 га-д үр тариа, үүнээс улаан буудай 18627 га, арвай 261 га, овъёос 126 га-д, мөн малын тэжээл 1357 га, тосны ургамал 300 га, төмс 295 га, хүнсний ногоо 204 га талбайд тариалсан нь улаан буудай 3127 га, арвай 21 га, овъёос 41 га, малын тэжээл 407 га, төмс 6 га, хүнсний ногоо 18 га-гаар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ургац хураалтын дүнгээр үр тариа 28385 тн, үүнээс улаан буудай 27957 тн, арвай 287 тн, овъёос 141 тн, мөн малын тэжээл 5097 тн, тосны ургамал 75 тн, төмс 2963 тн хүнсний ногоо 2471 тооныг тус тус хураан авлаа.

Түнэл сумын Талын хонхорт ногоо тариалж буй иргэдийн газрыг Бүрэнтогтох сумын Эрчим багт шилжүүлэх зорилгоор тухайн багийн нутагт төмс хүнсний ногоо тариалах боломжтой талбай, хөрс бүхий газрыг сонгох зорилгоор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн Чинзориг, Мөрөн ногоочин Ж.Балдандорж, Цэнгэг ус компанийн захирал Даваадорж нарын хамт үзэж байршлын цэг тогтоосон.

ХХААХҮЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 оны хаврын тариалалтад нөөцөлсөн үрийн судалгааг сумдаас аж ахуйн нэгж иргэнээр нь гаргуулан авч нэгтгэн ГТБХЗГ-т хүргүүлсэн. Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 20 аж ахуйн нэгж 10 иргэнд 2022 оны тариалалтад зориулан 2199 тн буудайн үр нөөцөлсөн нь хаврын тариалалтад шаардлагатай улаан буудайн үрийн 86,6 хувийг бүрдүүлж нөөцөлсөн байна.

ХХААХҮЯ-наас зохион байгуулж буй “Өвлийн идэш” арга хэмжээнд сумдын малчид, иргэдийн бэлтгэсэн мах, сүү цагаан идээ зэрэг орон нутгийн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг оролцуулах ажлыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд 11 сумын 18 иргэн 86 тонн мах 16 тонн аарц, 6 тонн төрөл бүрийн цагаан идээтэй оролцлоо.

Монгол Улсад худалдаа хоол үйлдвэрлэлийн салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд хоол үйлдвэрлэлийн аж ахуйн нэгж байгууллагууд болон сонирхогч иргэдийн дунд өөрийн аймгийн үндэстэн ястнуудын хоолны өв соёлыг сэргээх, залуу хойч үед сурталчлах, уламжлалт хоолны ёс заншлыг сэргээн дэлгэрүүлэх орон нутгийн онцлог хоолыг илэрхийлэх зорилгоор Цаатан, Дархад, Халх, Урианхай, Хотгойд, Буриад үндэстний “Хоймор нутгийн зоог-2021” хоолны үзэсгэлэн гаргалаа. Энэ үйл ажиллагааг дэмжиж ЗДТГ-аас 1200,000 төгрөгний дэмжлэг үзүүллээ.

## **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Архитектур төлөвлөлтийн даалгавар: Ашиглагч байгууллагын ажлын даалгавар, захиалагчийн хүсэлтийн дагуу нийт 8 барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан аймгийн ерөнхий архитектороор батлуулан, холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Зургийн даалгавар : Ашиглагч байгууллагын ажлын даалгавар, захиалагчийн хүсэлтийг үндэслэн нийт 19 барилга байгууламжийн засвар, шинэчлэлт, угсралтын ажлын зургийн даалгаврыг боловсруулан захиалагчаар батлуулж, холбогдох байгууллагад хүргүүлэв.

#### Техникийн нөхцөл олголт

Хууль, дүрмийн дагуу 2021 оны 10 сарын 15-наас дараа оны 4 сарын 15 хүртэл техникийн нөхцөл олгох үйл ажиллагаа зогссон.

#### Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон байдал

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу улс, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх 8 барилга, байгууламжид холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ажил эхлэх зөвшөөрлийг олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжид захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал:

Улс, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 14 /жагсаалтаар оруулах/ барилга, байгууламжийн ажлын явцад захиалагчийн хяналтын хийж, үүссэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллалаа. 2021 оны 11 сарын 10-наас Аймгийн мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн 2/425 дугаартай ажил зогсоох тухай албан бичиг, ГХБХБГазрын даргын 2021.11.18-ны өдрийн 4/894 дугаартай албан бичгээр барилга байгууламжийн ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл технологийн түр зогсолт хийхийг цахим болон цаасан хэлбэрээр аж ахуй нэгжид хүргэж ажлыг зогсоосон.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн барилгын гадна фасадын ажил - 2 удаа хяналт тавьж ажилласан. дараах үүрэг даалгавар өгсөн. Үүнд: Зураг төсөвт барилгын 4 талыг хөөсөнцөр хавтангаар дулаалахаар тусгагдсан гүйцэтгэл дээр баруун тал хойд талыг хөөсөнцөр хавтангаар дулаалж зүүн тал, урд талыг хусаж эмульсдэх ажил хийгдэж байв. Зураг төсөлд 10см-н 20метр кубын хөөсөнцөр хавтанг 7см-н гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй хөөсөнцөр хавтангаар гүйцэтгэж байсан.

#### Улсын комисс ажилласан барилга байгууламж:

“Хөвсгөл Геологи” ХК-ийн гүйцэтгэсэн Шинэ Мөрөн хорооллын 55 айлын орон сууцны IV блокын барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллав. Их-Уул сумын төвийн хог хаягдлыг зайлуулах ажлыг хүлээж авах комисс ажиллав. Дараах барилга байгууламжийн ажилд комисс ажиллах захирамж гаргуулж байна. Үүнд:

- Цагаан-Уул сумын дотуур байрын засварын ажил



- Шинэ-Идэр сумын Ахмадын өргөөний барилга
- Тариалан сумын бэлчээрийн гүний худаг
- Тосонцэнгэл сумын бэлчээрийн гүний худаг
- Мөрөн сумын 1,3км авто замын засварын ажил
- Ренчинлхүмбэ сумын Жаргантын голын гүүрийн засвар
- Улаан-Уул сумын Багтагийн голын гүүрийн засвар
- Улаан-Уул сумын Өл тоомын давааны гүүрийн засварын ажил
- Мөрөн нисэх буудлын хүлээн авахын засварын ажил

Хот байгуулалтын кадастрын цахим систем:

Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд сумын төвийн нийгмийн дэд бүтцийн болон бусад барилгыг бүртгэх ажлыг зохион байгуулж байна. Үүнд: Одоогийн байдлаар Төмөрбулаг, Арбулаг, Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Ханх сумдыг хамруулан ажиллаж байна.

Барилгын материалын лаборатори:

Барилгын материалын лабораторид 2021 оны 11 сард 5 байгууллагаас ирүүлсэн 51 дээж хүлээн авч шинжилгээ хийж хариуг олгов.

**Долоо. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн чиглэлээр**

Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу Алаг-Эрдэнэ, Хатгал, Рашаант, Их-Уул, Тосонцэнгэл сумдад ажиллаж мод бэлтгэлийн талбай тусгаарлалт, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, арга хэмжээний зардлын зарцуулалт, эрхийн бичиг олголтод хяналт шалгалт хийлээ.

2022 оны мод бэлтгэх дээд хязгаарыг батлуулах төслийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлсэн. “Тэрбум мод” тарих хөдөлгөөнд 2022-2030 онд таригдах модны судалгааг гаргаж БОАЖЯаманд хүргүүлсэн.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИНУБАТ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
 МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА